ДУНДГОВЬ АЙМАГ
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 16 өдөр    Дугаар А/02    Рашаант

Сумын 2018 оны Авлигын эсрэг
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх сумын "Авлигын эсрэг 2018 оны төлөвлөгөө"-г хавсралтаар батлсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан хэрэгжүүлж, "Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ын дагуу тайлан мэдээг гаргаж үнэлүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Хорлоо)-д үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлан төсөв батлуулан зарцуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, байнгын хяналт тавьж, тайланг (нотлох баримт, бусад материалын хамт) 11 дүгээр сарын 01-ний дотор Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, зүйн хэлтэст хүргүүлж тайлагнахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Хорлоо), төсөв шууд захирагч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА    А.ЭРДЭНЭБАТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2018 оны 01 сарын 16-ны өдрийн 11/02 тоот захирамжийн хавсралт

# ӨЛЗИЙТ СУМЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.01.16

- **Зорилго:** Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн авлига, хүнд сурталаас ангид, хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэх.

**Зорилт 1.** шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;
**Зорилт 2.** төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;
**Зорилт 3.** төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;
**Зорилт 4.** худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;
**Зорилт 5.** авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;
**Зорилт 6.** шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаag үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

| № | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | ХУГАЦАА | ХАРИУЦАГЧ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАН | ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР | ОНОО 0-5 |
|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх; | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.1 | Төрийн захиргааны албан тушаал, нийтийн албан тушаалд томилгооны зөрчилгүй ажиллана | Жилдээ | Хорлоо | АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ЗОХИХ ШААРДЛАГЫН ДАГУУ ХАРИУЦЛАГА ИЛ ОД БАЙДАЛ БҮРЭН ХАНГАГДАНА. | |

**Зорилт 2.** төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.1 | Төрийн албан хаагчдыг нэрсээр санал асуулга авах ил тод мэдээлэх | 2 –р улиралд | Б. Хорлоо | ХАРИУЦЛАГА САЙЖИРНА. | |
| 2.2 | Төрийн албан хаагчдын 3 –р зөвлөгөөн зохион байгуулах | 4 улирал | Б. Хорлоо | ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРСАН ЗӨВЛӨЖИЙН ДАГУУ ДАРААГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛНА | |
| 2.3 | Нээлттэй хаалганы нэгдсэн өдөрлөг зохион байгуулах | 2 улиралд | Б. Хорлоо | Засаг даргын 100 дахь хоногийн тайлант өдөрлөгийг нээлттэй хаалганы зарчмаар зохион байгуулж үйлчилүүлэгчдээс санал асуулга авах | |

**Зорилт 3.** төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.1 | Байгууллага бүр Засгийн газрын 143-р тогтоолын дагуу төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана. | жилдээ | Төсөв шууд захирагч нар | Байгууллагын үйл ажиллагаагы ил тод байдал хангагдана | |
| 3.2 | Сум хөгжлийн сангийн зээлийн танилцуулга өдөрлөг зохион байгуулах | 12 сард | Н.Отгонсүрэн | Зээлийн үр ашиг, зориулалт , хариуцлага иргэдэд бодит үр нөлөө өгнө. | |

**Зорилт 4.** худалдан авах ажиллагааны хүрээг үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.1 | Байгууллага бүр худалдан авах ажилагааны тайлант мэдээлэл тогтмол хийх | жилдээ | Төсөв шууд захирагч нар | Мэдээллийн цагаар тогмол хийх, цахим мэдээлээр танилцуулах | |
| Зорилт 5. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих | | | | | |
| 5.1 | Иргэний нийгмийн байгууллагуудтай гэрээ байгуулж иргэдийн үнэлгээ авах, хэлэлцүүлэг хийх | жилд | Төсөв шууд захирагч нар | Хамтын ажиллагаа өргөжинө. | |
| Зорилт 6. шударга ёсны үзэл санаат төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаар үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх. | | | | | |
| 6.1 | Иргэдэд төрөл бүрийн сургалт сурталчилгаа зохион байгуулах | жилд | Төсөв шууд захирагч нар | Хамтын ажиллагаа өргөжинө. | |

Тайлбар: 1 зорилт 1 бүтээлч ажил 1 үр дүн нийт 6 ажлыг бүрэн хэвшмэл ажил болгон зохион байгуулахад оршино.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН :

ЗДТГ-ЫН ДАРГА Б. ХОРЛОО